



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН САЙДЫН
ТУШААЛ

2026 оны 08 сарын 31 өдөр

Дугаар A/276

Улаанбаатар хот

Чиглэл батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Боловсролын ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.24 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын гэрийн даалгаврын талаар баримтлах чиглэлийг хавсралтаар баталсугай.

2.Хавсралтаар баталсан чиглэлийг 2026–2027 оны хичээлийн жилээс эхлэн хэрэгжүүлэхийг өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт, нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж, багш нарт мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн боловсролын газрын дарга нар, Боловсролын ерөнхий газар (Х.Тамир)-т тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (В.Түвшинжаргал)-т даалгасугай.

САЙД



Л.ЭНХ-АМГАЛАН

1426010774

Боловсролын сайдын
2026 оны 08 дугаар сарын 31 ний өдрийн
А/246 дугаар тушаалын хавсралт

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН СУРАЛЦАГЧДЫН ГЭРИЙН ДААЛГАВРЫН ТАЛААР БАРИМТЛАХ ЧИГЛЭЛ

Нэг. Нийтлэг үндэслэл

Гэрийн даалгавар нь хичээлээр эзэмшсэн мэдлэг, чадварыг бататгах, гүнзгийрүүлэх, бие даан суралцах чадварыг хөгжүүлэх чухал арга хэрэгсэл боловч даалгаврын хэмжээ, давтамж зэрэг нь суралцагчийн нас, хөгжлийн онцлог болон тухайн өдрийн нийт сургалтын ачаалалтай нийцээгүй тохиолдолд суралцах үр дүнд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй юм.

Тухайн ангийн суралцагчдын түвшинд тохируулан гэрийн даалгаврын өдрийн дээд хязгаарыг тооцох, суралцагчдын гэр бүлийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлын ялгааг харгалзан гэрийн даалгаврыг уян хатан, тэгш хүртээмжтэй байлгах, олон улсын нийтлэг сайн туршлагыг харгалзах талаар олон улсын боловсролын чиглэлийн судалгааны бүтээлүүдэд зөвлөмжилсөн байна.

Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр шинэчлэгдэн хэрэгжиж эхэлж байгаа энэ үед гэрийн даалгаврыг зөвхөн мэдлэг давтан эзэмшүүлэх бус, суралцагчийн бие даан суралцах, асуудал шийдвэрлэх, бүтээлчээр сэтгэх, мэдлэгээ бодит нөхцөлд хэрэглэх чадварыг хөгжүүлэх сургалтын нэг хэсэг болгон шинэчлэн зохицуулах шаардлагатай байна.

Энэхүү чиглэлийг суралцагчийн бие даан суралцах чадвар, хариуцлага, мэдлэгээ бататгах болон амьдралын зөв дадлыг төлөвшүүлэх зорилгоор суралцагчийн нас, хөгжлийн онцлог, анги, түвшин, суралцах хэрэгцээнд нийцүүлэн гэрийн даалгаврыг оновчтой төлөвлөх, өгөх, гүйцэтгүүлэх, үнэлэхэд баримтална.

Хоёр. Гэрийн даалгаврын үндсэн зарчмууд

Багш суралцагчдад гэрийн даалгавар төлөвлөж, өгөхөд дараах үндсэн зарчмыг заавал баримтална.

2.1. *Зорилготой байх:* Гэрийн даалгавар нь тухайн хичээлийн суралцахуйн зорилт, агуулгыг бататгах, бодит амьдралд хэрэглэх болон бие даан суралцах чадварыг хөгжүүлэхэд тодорхой чиглэсэн байна.

2.2. *Нас, хөгжлийн онцлогт нийцсэн байх:* Суралцагчийн насны болон хувийн хөгжлийн онцлог, суралцах чадварын түвшин, ачааллыг харгалзан, ялгаатай байдлаар уян хатан төлөвлөнө.

2.3. *Хугацааны зохистой хязгаартай байх:* Нэг даалгавар болон тухайн өдрийн нийт гэрийн даалгаварт зарцуулах хугацааг насны онцлогт тохирсон дээд хязгаараар нарийн тооцох

2.4. *Чанартай бөгөөд үр дүнтэй байх:* Суралцах үр дүнд шууд нөлөөлөхгүй, олон дахин хуулбарлах механик болон ач холбогдол багатай дасгал өгөхөөс бүрэн татгалзана.

2.5. *Бие даан гүйцэтгэх боломжтой байх:* Эцэг эх, асран хамгаалагчийн шууд туслалцаа, зааварчилгаа шаардахааргүй, суралцагч өөрөө бие даан хийх боломжтой хэмжээнд байна.

2.6. *Амралт, чөлөөт цагийг хүндэтгэх:* Суралцагчийн унтаж амрах, дасгал хөдөлгөөн хийх, гэр бүлтэйгээ харилцах, нийгэмших, өөрийн сонирхлоор хөгжих цаг хугацааг хязгаарлахгүй байхаар тохируулна.

2.7. *Үр дүнг эргэх холбоотой болгох:* Өгсөн даалгаврыг багш шалгаж, суралцагчид ойлгомжтой, чиглүүлсэн, ахиц дэвшлийг дэмжсэн эргэх холбоог цаг тухайд нь өгдөг байна.

Гурав. Гэрийн даалгаврийн төрөл, түвшин

3.1. Гэрийн даалгаврын төрөл

Сургалтын зориулалт болон хүрэх үр дүнгээс хамааран гэрийн даалгаврыг дараах төрөлтэй байна.

- 3.1.1. *Бататгах даалгавар*: Суралцагч ангид 90-ээс доошгүй хувийг эзэмшсэн мэдлэг, чадварыг бататгах, хэвшүүлэхэд чиглэнэ.
- 3.1.2. *Бэлтгэл даалгавар*: Дараагийн хичээлээр судлах шинэ сэдэв, агуулгатай урьдчилан танилцуулахад чиглэнэ.
- 3.1.3. *Судлах даалгавар*: Явцын болон эцсийн үнэлгээний өмнө суралцагчид сургалтын материалыг бие даан судлах, мэдээлэл цуглуулах, ажиглах, турших болон системчлэх боломж олгоход чиглэнэ.
- 3.1.4. *Бүтээлч даалгавар*: Эзэмшсэн мэдлэг, чадвараа шинэ нөхцөл байдалд хэрэглэх, эргэцүүлэн бодох, ярилцах, судлан шинжлэх сонирхлыг хөгжүүлэхэд чиглэнэ.
- 3.1.5. *Нэгтгэх даалгавар*: Хэд хэдэн ур чадварыг зэрэг ашиглахыг шаардах төсөл, судалгааны ажил, эсээ бичих зэрэг хэлбэртэй, цогц асуудлыг шийдвэрлэхэд чиглэнэ.

3.2. Ялгаатай байдлыг дэмжих түвшин

Суралцагчдын мэдлэг, чадварын түвшний ялгаатай байдлыг харгалзан гэрийн даалгаврыг дараах түвшинд санал болгож, суралцагч тус бүрийн хэрэгцээнд нийцүүлнэ.

- 3.2.1. *Суурь түвшин*: Ангид заасан агуулгын 90 хувийг эзэмшсэн суралцагчид бие даан гүйцэтгэх бүрэн боломжтой даалгавар.
- 3.2.2. *Дунд түвшин*: Багшийн чиглүүлэг, дэмжлэг болон нэмэлт зааварчилгаатайгаар гүйцэтгэх даалгавар.
- 3.2.3. *Ахисан түвшин*: Өмнө эзэмшсэн мэдлэгээ өргөтгөн, гүнзгийрүүлж, бүтээлчээр ашиглаж асуудал шийдвэрлэх даалгавар.

Дөрөв. Гэрийн даалгаврын хугацаа, зохион байгуулалт

4.1. Гэрийн даалгаврын хэмжээг анги ахих тусам аажмаар нэмэгдүүлэх, бага ангид хамгийн бага хэмжээгээр тогтоохыг чухалчилна.

4.2. Нэг өдөрт суралцагчид өгөх гэрийн даалгаврын нийт дээд хугацааг дараах байдлаар тооцно:

$$T = 10 \times G$$

Үүнд: *T* - *хоногт гэрийн даалгавар хийхэд зарцуулах дээд хугацаа (минутаар)*; *G* - *суралцаж буй ангийн дугаар (1–12) байна.*

4.3. Ангис хамаарсан гэрийн даалгаврын өдрийн дээд хязгаарыг тогтооход дараах зарчмыг баримтална. Үүнд

- 1-4 дүгээр анги: Өдрийн дээд хязгаар 10-40 минут байна. Суралцагчийн хөгжлийн онцлогоос хамааран ялгаатай байж болно.
- 5-8 дугаар анги: Өдрийн дээд хязгаар 50-80 минут байна.
- 9-12 дугаар анги: Өдрийн дээд хязгаар 90-120 минут байна. Элсэлт, шалгалтад бэлтгэх шаардлагыг харгалзан аажмаар нэмэгдүүлж болно.

4.4. Судлагдахуун тус бүрийн гэрийн даалгаврын хугацааг бусад хичээлийн даалгавар гүйцэтгэх хугацаатай уялдуулан тухайн өдрийн даалгаврын нийт хугацаа энэхүү чиглэлийн 4.3-т заасан хязгаараас хэтрүүлэхгүй байхаар тооцно.

4.5. Суралцагчийн гэрийн даалгавар гүйцэтгэх хугацааг бичих, зурах, дүрслэх, бүтээх, тоо бодох зэрэг бодит үйлд зарцуулах хугацааг баримжаалж тооцно.

4.6. Долоо хоногийн амралтын өдөр, нийтээр амрах баярын өдөртэй холбогдуулан даалгаврын хэмжээг нэмэгдүүлэхээс зайлсхийнэ.

4.7. Даалгаврын агуулга нь давтагдсан, механик хуулбарлах болон бэлэн цээжлэх шинжтэй байхаас татгалзаж, суралцагчийн танин мэдэхүйг дэмжсэн байна.

4.8. Сургууль нь суралцагчдын гэр бүлийн нийгэм, эдийн засгийн байдлын ялгаанаас үл хамааран даалгавраа гүйцэтгэх тэгш боломжийг хангаж, гэрийн орчинд интернэт эсвэл техник хэрэгслийн хүртээмжгүй суралцагчид номын сан, бие даан хөгжих зориулалт бүхий зай талбайг ашиглан сургууль дээрээ даалгавраа хийх боломжийг бүрдүүлнэ.

4.7. Багш нь даалгаврын санг урьдчилан бүрдүүлж, төрөл, түвшнийг суралцагчдын ялгаатай байдал, сурах чадварт нийцүүлнэ.

4.8. Багш гэрийн даалгаврыг анги нийтээр болон бүлгээр, эсвэл ганцаарчилсан хэлбэрээр тогтмол шалгаж, алдааг залруулах зөвлөмж өгөх байдлаар эргэх холбоог хангаж ажиллана.

4.9. Ялгаатай хэрэгцээтэй суралцагчдын хөгжлийн онцлог, сурах хэрэгцээнд нь тохируулан гэрийн даалгаврын хэмжээг хөнгөвчлөх, тусгай тохируулгатай даалгавар санал болгох зэргээр уян хатан хандах зохицуулалтыг хэрэгжүүлнэ.

4.10. Суралцагчийн гэрийн даалгаврын явц, гүйцэтгэлийн үр дүнтэй холбоотой мэдээллийг олон нийтийн сүлжээгээр (Facebook, Viber г.м) нийтлэх, бусдад түгээхийг хориглоно. Сургуулийн албан ёсны зөвшөөрөгдсөн, боловсролын зориулалттай тусгай цахим суваг, системээр дамжуулан эцэг эх, асран хамгаалагчдад мэдээлж болно.

4.11. Эцэг эх, асран хамгаалагч нь суралцагч гэртээ даалгавраа хийх тохиромжтой, тайван орчныг бүрдүүлэх, цаг ашиглалтад туслах, бэлэн хариулт өгөхгүй, өөрөө бие даан хийхэд нь чиглүүлэх, хэт их ачаалалтай эсэхийг ажиглан багштай санал солилцож хамтран ажиллана.

4.12. Суралцагч нь гэрийн даалгаврын зааварчилгаа, шаардлагыг бүрэн ойлгож, заасан хугацаанд бие даан бүтээлчээр гүйцэтгэхийг эрмэлзэх ба ойлгоогүй, хүндрэлтэй зүйл гарвал тусгайлан тэмдэглэж, дараагийн хичээл дээр багшаас асууж тодруулна.

Тав. Бусад

5.1. Энэхүү чиглэлийн хэрэгжилтэд сургуулийн захирал, сургалтын менежер болон багш нарын зөвлөл тогтмол хяналт тавина.

5.2. Сургууль нь суралцагч, эцэг эх, асран хамгаалагчдад энэхүү чиглэлийг танилцуулж, суралцагчийн гэрийн даалгаврын ач холбогдол үр дүнг сайжруулах чиглэлээр хамтран ажиллана.

5.3. Суралцагчид, эцэг эх, асран хамгаалагчдаас гэрийн даалгаврын талаар сэтгэл ханамжийн авч, үр дүнг тусган зохион байгуулалтыг сайжруулж ажиллана.

5.4. Гэрийн даалгаврын гүйцэтгэл, үр дүнг хянах, мэдээлэл солилцоход суралцагчийн нэр төр, хувийн нууцлалыг хүндэтгэнэ.